Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Соёл, урлагийн газрын 2026 оны
01 дүгээр сарын 06-ны өдрийн
01/09 дугаар албан бичгийн
нэгдүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо /1/	Хувийн жин /1/
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт/3/ (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх /4/		1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх /5/		1	1	100
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агууллгын хүрээнд зохион байгуулсан эсэх /6/	0,5	0,5	100
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал /7/	0,5	0,5	100
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал /8/	0,5	0,5	100
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маяг бөглөсөн байдал /9/	0,5	0,5	100
Хэсгийн оноо				**4**	**4**	**400**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх/10/ *(гаргасан дүгнэлтийг хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал /11/		1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал /12/		1	0.5	50
Хэсгийн оноо				**3**	**2.5**	**250**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал /13/		1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /14/ *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт*		1	1	100

		ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно.)			
9		Ёс зүйн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал /15/	1	1	100
Хэсгийн оноо			**3**	**3**	**300**
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**9.5**	**95%**

Эзлэх хувь = $\frac{(\text{ҮХХ+ЁЗМ+ЁЗДХ})}{10}$ *100= $\frac{(4+2.5+3)}{10}$ *100= **95%**

Тайлбар:

/1/ Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

/2/ Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

/3/ УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

/4/ ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

/5/ ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар “Аргачлал батлах тухай” тогтоол.

/6/ УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

/7/ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

/8/ ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3 , мөн оны 07 дугаар “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар арга хэмжээний тухай” тогтоол.

/9/ ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар “Загвар батлах тухай” тогтоол.

/10/ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

/11/ Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

/12/ Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

/13/ ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт

/14/ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

/15/ ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3,4.4.4 дэх заалт.

---oOo---

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Соёл, урлагийн газрын 2024 оны
01 дүгээр сарын 06-ны өдрийн
01/09 дугаар албан бичгийн
хоёрдугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ,УРЛАГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Агентлагийн даргын 2025 оны 05 сарын 12-ны өдрийн А/21 тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан. Байгууллагын Ёс зүйн дэд хороо 2025 онд 3 зорилтын хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав.Соёл, урлагийн газар нь 37 албан хаагчтай бөгөөд 2025 онд ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын сахилга хариуцлага алдаж холбогдох хууль, журмын дагуу албан тушаалтанд хариуцлага тооцох нөхцөл байдал үүсээгүй тул ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гараагүй болно.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
- Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 2 сард зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах" цахим сургалтад 3 албан хаагч хамрагдаж "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" болон Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэсэн мэдээллийг хянах заавар, зөвлөгөө авч ажиллав. - Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан "Төрийн албаны ёс зүй, манлайлал, байгууллагын соёл" танхимын сургалтад агентлагийн Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн хамрагдав. Сургалтаар Төрийн албаны болон албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх, ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр мэдээлэл өгөв. - Агентлагт шинээр ажилд томилогдсон 11 албан хаагчийг чиглүүлэх, ажлын байранд дадлагажуулах сургалтад хамруулав. Сургалтаар төрийн албан хаагчийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх, мэргэшил, мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн залгамж халааг бэлтгэх, үйл ажиллагааны зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагын соёл, үйл ажиллагаа, тогтолцооны хүрээнд мэдлэг олгов. - Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт танхимын сургалтыг 2025 оны 5 болон 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж нийт 35 албан хаагч хамрагдав. Тус сургалтаар авлигын хор хөнөөл, ангилал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", авлигын гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх зэрэг сэдвээр сургалт мэдээлэл өгөв. Энэхүү сургалт нь төрийн байгууллагуудын "Авлигын эсрэг

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.
[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөмж, кейс, жишээнд тулгуурлан харилцан санал солилцсон үр дүнтэй сургалт болсон.

- Судлаач Ж.Баясгалан багштай “Байгууллагын соёл ба ёс зүй” сэдвээрх танхимын сургалтыг 2025 оны 9 сарын 10-ны өдөр зохион байгуулав. Сургалтад 35 албан хаагч хамрагдаж төрийн албаны ёс зүй, байгууллагын соёл ба ёс зүйн тухай ойлголт, байгууллагын соёлын өөрчлөлтөөр дамжуулан ёс зүйг дэмжсэн орчин, нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр мэдлэг ойлголт авсан. Энэхүү сургалт нь эерэг хандлага төлөвшүүлж, хамт олны эв нэгдэл, таатай уур амьсгалыг дэмжих замаар албан хаагчдын ажлын бүтээмж, ур чадварыг сайжруулах ач холбогдолтой юм.
- Ёс зүйн хорооноос 2025 оны 11 сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” цахим сургалтад агентлагийн 35 албан хаагч хамрагдав. Тус сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хийх, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах талаар арга зүйн заавар зөвлөмж өгөв.
- Ёс зүйн хорооноос зохион байгуулж буй “Хүндэлье, энэрье” аянд нэгдэж ажлын орчин, гэр бүл, найз нөхдийн дунд хүндлэл, эелдэг найрсаг харилцааг төлөвшүүлэх, дэмжих, урамшуулах соёлыг түгээн дэлгэрүүлэх, бие биедээ туслах, дэмжих, өгөөмөр сэтгэлээр хандах, энэрэх, өршөөж уучлах зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 1-11 сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулж, тус аяны талаарх 3 постер бэлтгэн байгууллагын цахим хаягаар олон нийтэд түгээсэн.
- Ёс зүйн хорооноос 2025 оны 11 сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” цахим сургалтад агентлагийн 35 албан хаагч хамрагдав. Тус сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хийх, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах талаар арга зүйн заавар зөвлөмж өгөв.
- Монгол улс Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 06 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-г агентлагийн удирдах 6, гүйцэтгэх 30, нийт 36 албан хаагчдыг хамруулав.Төрийн албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудлаар ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлоход нийт албан хаагчдын 70 хувь нь 1-5 оноотойгоор эрсдэлийн IV түвшин буюу бага эрсдэлтэй, 6-10 оноотойгоор дунд зэргийн эрсдэлийн түвшинд тус тус үнэлэгдлээ. Тус үнэлгээгээр эрсдэлийн I, II түвшинд үнэлэгдсэн (12-25 оноо) маш өндөр, өндөр эрсдэл бүхий албан тушаал эрхэлдэг албан хаагч байхгүй гэсэн үр дүн гарсан тул “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг” гаргах шаардлагагүй байна. Харин байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг 58 хувь нь IV түвшин буюу бага эрсэлтэй, 27 хувь нь III түюшин буюу дунд эрсдэлтэй, 9 хувь нь II түвшин буюу өндөр эрсдэлтэй, 6 хувь нь I түвшин буюу маш өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдлээ. Тус үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна.
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” , “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)", агентлагын 2025 оны “Ёс зүйн дэд хороо”-ны төлөвлөгөө тайланг байгууллагын цахим хуудас *(https://e-mongolia.mn/org/culture/transp/stats)*-д байршуулав.
- Агентлагийн "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн тайлан"-г цаглаварт хугацаанд гарган Монгол Улсын Ёс зүйн хорооны цахим систем (*https://hrm.csc.gov.mn*)-д оруулж баталгаажуулав.
- Ес зүйн дэд хороо-ны 2025 оны үйл ажиллагааны холбогдох баримт материалыг архивын хадгаламжийн нэгжийн дагуу архивлаж, агентлагийн архивд хүлээлгэн өгсөн.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Агентлагийн удирдлага нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлах соёлыг төлөвшүүлэх, албан хаагчдын сэдэл, урам зориг, дадлыг бий болгоход чиглэсэн бүтээлч ажлыг идэвхжүүлэх, соёлыг түгээх, хэвшүүлэх, хүний нөөцийн ил тод нээлттэй бодлого хэрэгжүүлэх, ажлын байрны таатай орчныг бүрдүүлэх, албан хаагчдыг хөгжүүлэх сургалт, хөгжлийн хөтөлбөрийг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2.3 Ёс зүйн хорооны үйл ажиллагаа:

Агентлагийн даргын 2025 оны А/21 тоот тушаалаар Ёс зүйн дэд хорооны 3 гишүүнийг шинэчлэн томилсноор тус онд бүрэн бүрэлдэхүүнтэй чиг үүргээ хэрэгжүүлэв. Ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны зорилтоо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан дүрэм, журам, үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөлөө батлуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлэн ажиллаж байна.

Ёс зүйн дэд хорооноос хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар нэгдмэл ойлголт өгч, арга зүйгээр хангахын зэрэгцээ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, ашиг сонирхлын зөрчил, байгууллагын соёл зэрэг сэдвээр танхимын 5 сургалт, цахим 4 сургалтад тус тус албан хаагчдыг хамруулав.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл
-“Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлийн үнэлгээ”-г анх удаа хийж албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх эрсдэлийн түвшинг тодорхойлж, байгууллагын соёлыг үнэлж санал, зөвлөмж боловсруулав. - Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд зөвлөн туслах, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулах ажлуудыг тусгахаар төлөвлөсөн. - Албан хаагчдын төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж ёс зүй аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн.	- Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг албан хаагчдад ойлгомжтойгоор таниулаагүй. -Эерэг харилцааг урамшуулах, албан хаагчдын ажиллах ажлын байрны таатай орчин бүрдээгүй -Ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол, хэрэгжүүлэхэд санхүүгийн нөөц, боломж хязгаарлагдмал - Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хуулиар заасан урамшууллыг цаглаварт хугацаанд нь олгодоггүй

Санал:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүний хэрэглээ, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим сургалтыг зохион байгуулах;
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо системд суурилсан Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн хөгжүүлэлт, ашиглалтыг сайжруулах;
- Ёс зүйн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг ойлгомжтойгоор боловсруулах, арга зүйгээр хангах;
- Төрийн албанд хүний нөөцийн нээлттэй бодлого хэрэгжүүлэх, албан хаагчдын карьерийн өсөлт хийх боломжийг хангах.

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, Сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ын дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Г.БАТХУЯГ

(Албан тушаалтан)	*(Гарын үсэг)*	*(Гарын үсгийн тайлал)*

Ёс зүйн дэд хорооны дарга

Н.ЦАЦРАЛ

(Албан тушаалтан)	*(Гарын үсэг)*	*(Гарын үсгийн тайлал)*

Ёс зүйн дэд хорооны
нарийн бичгийн дарга

О.ГАНБОЛД

(Албан тушаалтан)	*(Гарын үсэг)*	*(Гарын үсгийн тайлал)*

Огноо: 2026 оны 01 дүгээр сарын 02

---oOo---

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Соёл, урлагийн газрын
2026 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн
01/09 дугаар албан бичгийн
гуравдугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Төсөв	Хугацаа	Хариуцах гишүүн
Нэг. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд						
1	Агентлагийн албан хаагчдад зориулсан ёс зүй, байгууллагын соёлын танхимын сургалт, арга хэмжээг зохион байгуулах	Сургалтын тоо	Нийт 35 албан хаагчийг хамруулсан байна.	-	Улирал бүр	Нарийн бичгийн дарга
2	Агентлагийн албан хаагчдад зориулсан байгуулсан Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн цахим сургалтад нийт албан хаагчдыг хамруулах	Сургалтын тоо	Нийт 35 албан хаагчийг хамруулсан байна.	-	Хагас жил	Нарийн бичгийн дарга
3	Агентлагт шинээр томилогдсон албан хаагчид ёс зүйн хууль тогтоомжийг танилцуулах, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах	Сургалтын тоо	Шинээр томилогдсон албан хаагч бүрт нэг удаа зөвлөмж өгсөн байна.	-	Тухай бүр	Ёс зүй дэд хорооны дарга
4	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, уриалга боловсруулж, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, сурталчлах *(постер, контент)*	Түгээсэн постерийн тоо	Хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэвлүүлж түгээсэн байна.	-	Бүтэн жил	Ёс зүй дэд хорооны бүрэлдэхүүн
5	"Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулах	Сургалтын тоо	Нийт 35 албан хаагчийг хамруулсан байна.	-	Бүтэн жил	Ёс зүй дэд хорооны бүрэлдэхүүн
6	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамруулах.	Сургалтын тоо	Зөрчил хянан шийдвэрлэх чадамж дээшилнэ.	-	Хагас, бүтэн жил	Ёс зүй дэд хорооны дарга

Хоёр. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах зорилтын хүрээнд						
7	Ажилтан албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэх					
8	Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоож, хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дүгнэлт гаргаж, дүгнэлтийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэх.	Тайлангийн тоо	Тэмдэглэл, дүгнэлт	-	Тухай бүр	Ёс зүй дэд хорооны бүрэлдэхүүн
9	Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалах, мэдээллийн санд оруулах.	Тухай бүр	Ёс зүйн хорооны журмын хэрэгжилт хангагдсан байна.	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
10	Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.	Хүний тоо	Ёс зүйн мэдлэг ойлголт дээшилсэн байна.	-	Тухай бүр	Ёс зүй дэд хорооны бүрэлдэхүүн
Гурав. Ёс зүйн дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг тогтворжуулах зорилтын хүрээнд						
11	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх	Арга хэмжээний тоо	Төлөвлөгөө хэрэгжсэн байна	-	2 дугаар сар	Ёс зүй дэд хорооны дарга
12	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэн тайлагнах	Тайлангийн тоо	Журмын дагуу хуралдуулж хэвшсэн байна	-	Тухай бүр	Ёс зүй дэд хорооны дарга
13	Ёс зүйн дэд хорооноос хэрэгжүүлсэн ажлын талаар байгууллагын албан хаагчдад болон олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг бэлтгэж, агентлагийн цахим хуудсанд байршуулах	Байршуулсан мэдээллийн тоо	Олон нийтийг мэдээллээр хангасан байна	-	Тухай бүр	Ёс зүй дэд хорооны бүрэлдэхүүн
14	Ёс зүйн дэд хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр цаасан суурьтай албажуулах	Тухай бүр	Олон нийтийг мэдээллээр хангасан байна	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
15	Агентлагийн "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн тайлан"-г хагас бүтэн жилээр гаргаж, Монгол Улсын Ёс зүйн хорооны цахим (https://hrm.csc.gov.mn) системд тайлагнах	Системд оруулсан тайлангийн тоо	Үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр мэдээлж, тайланг бүтэн жилээр тайлагнасана.	-	Хагас, бүтэн жил	Ёс зүй дэд хорооны дарга

16	Дэд хорооны үйл ажиллагааг агентлагийн сайтад сурталчлах, тайлагнах, тайланг ёс зүйн хорооны цахим (https://hrm.csc.gov.mn) системд оруулах, баримт бичгийг байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Тайлангийн тоо	Үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр мэдээлж, тайланг хагас, бүтэн жилээр тайлагнана.	-	Бүтэн жил	Нарийн бичгийн дарга

---oOo---